

# ХОВД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

*Б. Баяртуяа*

*“Нийгмийн ажил” хөтөлбөрийн магистрант*

*Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль  
Шинжлэх ухаан технологийн их сургууль*

*ritaar\_4@yahoo.com*

*Хураангуй: Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)- аар дамжуулан орон нутгийн төр захиргааны байгууллага мөнгө санхүүг захиран зарцуулах эрх зүйн орчин бүрдснээр иргэн хүн өөрийн амьдарч байгаа сум, багийнхаа тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, амьдрах орчноо сайжруулах боломжийг бий болгосон нь төсвийн шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой хэдий ч жилийн гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад тулгамдаж буй асуудал байсаар байна. Уг асуудлын хүрэнд Ховд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн нөхцөл байдлыг судалж жилийн гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад тулгамдаж буй асуудал тодорхойлох зорилго агуулсан болно. Судалгааны хүрээнд 2013 оноос хойш орон нутгийн хөгжлийн сангийн нөхцөл байдлыг авч үзэхэд засаг дарга нар үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гол ажлууд дээрээ иргэдийн дэмжсэн саналыг авдаггүй, хурал иргэдээс ирүүлсэн саналыг хасдаг, иргэдээс зүгээс гүйцэтгэлийн хяналт тавихад оролцоо муутай байдаг нь түгээмэл байна. Нөгөө талаас ОНХС-аас хуваарилагдаж байгаа төсөв хүрэлцээ муутай, төлөвлөн ажлууд цагтай хийгдэхгүй байгаа зэрэг нь орон нутагт төрийн удирдлагын менежмент сул, аливаа ажлын захригааны аргаар явуулдаг байдал нь ажлын гүйцэтгэлд тавих хянал сул байдалд хүргэж байна. Иймд ОНХС-ийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын уялдаа хобоог сайжруулах, бүх шатандаа ил тод байдал, харууцлага сахилга дээшлүүлэх шаардлагатай.*

*Түлхүүр үгс: менежер, харууцлага, төлөвлөлт, үр дүн*

## **УДИРТГАЛ**

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг “Орон нутгийн хөгжлийн сан” гэж гэдэг. Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)- аар дамжуулан орон нутгийн засаг захиргаа мөнгө санхүүг захиран зарцуулах эрхтэй болсон, төсвийн шийдвэрт иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчин бүрдсэн, иргэн хүн өөрийн амьдарч байгаа сум, багийнхаа тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, амьдарх орчноо сайжруулах боломжийг бий болгосон байдаг. “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 2016 оноос эхлэн сумдын ОНХС-гийн үйл ажиллагаанд “Жилийн

гүйцэтгэлийн үнэлгээ”(ЖГҮ)-г хийж байна. ЖГҮ нь төслийн хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг болох “Сайн засаглал - Үр дүнд суурилсан дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хийгддэг ба үйл ажиллагаагаа сайн үнэлүүлсэн сумдад ОНХС-ийн өмнөх жилийн санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний урамшууллыг төсөвт суулган олгодог. Өөрөөр хэлбэл ОНХС-ийн үйл ажиллагаагаа хууль, тогтоомжийн дагуу зөв, зүйтэй зохион байгуулж, иргэдийнхээ оролцоог идэвхтэй байлгаж чадсан сумд ОНХС-ийн санхүүжилтээ нэмэгдүүлэх боломжтой.

Үнэлгээг бие даасан, хөндлөнгийн байгууллагуудаар сумдын ОНХС-ийн “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн нийт 34 үзүүлэлтээр дүгнэн хийлгэдэг. ЖГҮ хийсэн анхны жил буюу 2016 онд нийт 330 сумын дундаж оноо 31,62% байсан бөгөөд сумдын ОНХС-ийн үйл ажиллагаа эдгээр жилүүдэд сайжруулах тал дээр дээрх үзүүлэлтүүдээр сумдын ОНХС-ийн ерөнхий үйл ажиллагааг дүгнэх бөгөөд сумдын дундаж оноог өсгөх, сайжруулах шаардлагатай буюу бага оноо авсан үзүүлэлтүүдийг онгцойлон анхаарах, цаашлаад бүх үзүүлэлт, үйл ажиллагааг жигд өсгөхөд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж 2020 он гэхэд сумдын дундаж оноог 60%-д хүргэх зорилго тавин ажилласан.

Үүний хүрээнд орон нутгийн ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалтууд, иргэдийг мэдээллээр хангах зорилготой олон нийтэд хандсан мэдээлэл сурталчилгааны материал, нэвтрүүлгүүд бэлтгэн түгээх, сумын түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд орон нутгийн Засаг захиргаатай хамтран дэд төслүүдийг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн орчинг сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Төслөөс зохион байгуулсан дээрх үйл ажиллагаануудыг аймаг, сумдын холбогдох албан хаагчид, удирдлагуудтай хамтран хэрэгжүүлдэг бөгөөд үүний үр дүнд 2017 онд ЖГҮ-ий сумдын дундаж оноо 37.19%, 2018 онд 50.32%, 2019 онд 59.47% 2020 онд зорилтот түвшинд буюу 60,13%-д хүрсэн байна. 2021 оны ЖГҮ 8 дугаар сард хийгдсэн бөгөөд "Тогтвортой амьжиргаа-3" төслийн зүгээс ЖГҮ-ний 330 сумын дундаж оноог 70%-д хүргэх зорилт тавин ажилласан байна.

## **ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ**

Гүйцэтгэлийн удирдлагын талаар судлаач Их Британий Мишел Армстронг (Michael Armstrong) гүйцэтгэлийн удирдлага гэдгийг *“Хувь хүн ба бүлгийн гүйцэтгэлийг хөгжүүлэх замаар байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах системтэй үйл явц”*, Майк Волтерс (Mike Walters) *“Байгууллагын*

зорилгод хүрэхийн тулд ажилчдыг үр ашиг, үр нөлөөтэйгээр ажиллуулахыг дэмжих, удирдах үйл явц”, М.Армстронг, А.Барон ( Angela Baron) нар “Хувь хүн ба бүлгийн чадавхийг хөгжүүлэх замаар хүмүүсийн гүйцэтгэлийг сайжруулж, байгууллагын үр нөлөөтэй байдлыг тогтвортой хадгалах стратеги ба үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах үйл явц” гэжээ. Судлаач Т.В.Бачнер гүйцэтгэлийн удирдлагын үйл явцыг судалсны үндсэн дээр 2007 онд гүйцэтгэлийн удирдлага нь Зорилгын онол (Goal theory), Хяналтын онол (Control theory), Нийгмийн танин мэдэхүйн онол (Social cognitive theory) дээр суурилдаг болохыг тодорхойлсон байна.

Гүйцэтгэлийн удирдлага дараах зорилготой .Үүнд:

- *Стратегийн зорилго*- Ажын гүйцэтгэлийг байгууллагын зорилго, стратегитай уялдуулснаар үр дүнтэй ажиллах, байгууллагын стратеги болон зорилгын өөрчлөлтөд тохируулах боломжтой
- *Захиргааны зорилго*- Байгууллагаас хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, хариуцлага тооцох, тасралтгүй сургалт явуулснаар ажилтны гүйцэтгэл сайжирч байгууллагын ажил аүр дүн гарна. .
- *Хөгжлийн зорилго*- Нийтийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцтэй холбоотой удирдлагын шийдвэр нь чухал юм.

Гүйцэтгэлийн удирдлага бол менежментийн нэгдмэл үйл ажиллагаа үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэхэд менежерийн манлайлал чухал болно. *Гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын стратегийн зорилго, зорилтыг хангахын тулд гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор гүйцэтгэлийн зорилт дэвшүүлэх, гүйцэтгэлийг хэмжээсжүүлэх, гүйцэтгэлийн талаарх мэдээ баримтыг цуглуулах, явцыг хянах, тайлагнах, энэхүү мэдээ мэдээллийг ашиглах зэрэг тасралтгүй үргэлжлэх тогтолцоо ажээ.* Гүйцэтгэлийн удирдлага нь:

1. Зорилтуудыг тодорхойлож байгууллагын стратегийн зорилтуудтай уялдуулах;
2. Багийн болон ажилтны гүйцэтгэлийг зорилтуудтай харьцуулан тогтмол үнэлэх;
3. Ажлын явцад албан ба албан бус эргэх холбоог анхаарах өгөх;
4. Гүйцэтгэлээс хамаарсан цалин хөлс, шагнал урамшуулал олгох;
5. Бүх түвшинд ур чадварыг нь сайжруулахын тулд сургаж хөгжүүлэх;
6. Гүйцэтгэлийг удирдан зохицуулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх;
7. Хувь хүний хөгжлийг байгууллагын болон нэгжийн төлөвлөлттэй холбох;
8. Байгууллага болон багийн гүйцэтгэлд тухайн хүний оруулсан хувь нэмрийг үнэлэх зэрэг олон талыг хамарсан үйл ажиллагаа юм.

Орон нутгийн хөгжлийн сан нь 2013 оноос эхлэн бүх аймаг сумдад байгуулагдан орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн оролцоог хөгжүүлэх

чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг сурталчлах, иргэдийг гарын авлага, мэдээ, мэдээллээр тогтмол хангах нь иргэдийн амжиргааг дээшлүүлэх, орон нутгийн эрх мэдлийг өргөжүүлэх, нутгийг өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, төр иргэний харилцааг сайжруулах олон талыг үүрэгтэй. ОНХС-ийн үйл ажиллагааг нь удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ, гүйцэтгэл, тайлагнал, төлөвлөлтөөс бүрддэг. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үр дүн нь сум, баг бүрт харилцан адилгүй байна. Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад тулгамдаж буй асуудлууд сум, багийн засаг даргаас эхлээд иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн нийтийн хурал зэрэг бүх шатны байгууллагуудын оролцоо, нөлөөлөл, хамтын бодлого шийдвэр чухал үүрэгтэй.

### **СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Ховд аймгийн 17 сумын ОНХС хариуцан ажилладаг төсвийн мэргэжилтнүүдээс дараах асуулгаар судалгаа авч нэгтгэв. Судалгаанд 23-60 насны тухайн албанд 1-17 хүртэл жил ажиллаж байгаа 20 ажилтан хамрагдав.

- Сумын ОНХС-ийн ЖГҮ хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлж буй 3 шалтгааныг нэрлэх /Уг 3 шалтгааныг 1-3 хүртэл эрэмблэх/

Судалгааны дүнг нэгтгэн үзвэл: Сумын ОНХС-ийн ЖГҮ хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлж буй шалтгаанууд:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гол ажлууд дээр иргэдийн дэмжсэн саналыг авдаггүй
- Санал асуулгыг журмаар нь авдаггүй
- Хурал иргэдээс ирүүлсэн саналыг хасдаг
- Иргэдээс төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байдаг
- ОНХС-аас хуваарилагдаж байгаа төсөв хүрэлцээгүй
- Иргэдийн оролцоо сул, ялангуяа БИНХ-д оролцож, саналаа тэр бүр өгдөггүй ач холбогдол өгдөггүй
- Төсөвт байгууллагын төсөл хөтөлбөр санхүүжүүлдэг төсвийн дутагдсан зардал нөхөх мөнгө шиг үздэг
- Багийн ИНХ-ын эрэмблэлт үнэн зөв байдаггүй
- Нэр заасан ажлуудаа хийдэггүй өөр ажил хийгээд тайлангаа худлаа гаргадаг
- Багуудын Засаг дарга нарын мэдлэг чадвар дутмаг байдаг.
- Иргэдийн санал цаг хугацаанд нь авдаггүй
- Хувийн эрх ашгийг хангасан санал ирдэг энэ нь нийтийн эрх ашгийг зөрчдөг

- Төсөв тооцоолол муутай ажилд бага төсөв төлөвлөснөөс болж ажлын үр дүнд нөлөөлдөг
- Ямарч тооцоо судалгаагүй төсөвт байгууллагуудын тоног төхөөрөмжид хуваарилдаг
- Гүйцэтгэлд хяналт тавьдаггүй учраас гүйцэтгэлийн чанар муу хийгддэг
- ОНХС-ын мэдээлэл ил тод бус
- ОНХС-ын хөрөнгөөр үйлчилгээ үзүүлж, бараа материал нийлүүлж байгаа аж ахуй нэгж албан байгууллага ажил үйлчилгээ, үйл ажиллагаагаа тогтоосон хугацаандаа хийж гүйцэтгэдэггүй

*Шалтгаануудыг эрэмблэвэл:*

1. Иргэдэд хүрэх мэдээлэл муу, тэдний оролцоог хангаж чаддаггүй, иргэдийн хяналт сул байна.
2. Эрх бүхий албан тушаалтан, албан хаагчид журмын хэрэгжилтийг хангадаггүй, хориглосон зүйл заалтанд зарцуулдаг, гүйцэтгэлд хяналт тавьдаггүй.
3. ОНХС-аас хуваарилагдаж байгаа төсөв хүрэлцээгүй, хийгдэх ажлууд хугацаандаа хийгддэггүй гэсэн байна.

### **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Ховд аймгийн тухайд нийт 17 сумтай бөгөөд сүүлийн 4 жилийн сумдад хийгдсэн ЖГҮ-ны дүнг авч үзвэл 2016, 2017, 2018 онд тус бүр 3 сум, 2019 онд 5 сум, 2020 онд 8, 2021 онд мөн 8 сум босго оноо давж, ОНХС-гийн нийт санхүүжилтын 25%-ийг төсөвтөө нэмж суулгуулсан байна.

Ховд аймгийн “ТА-3” төсөл, аймгийн чадавхи бэхжүүлэх багийн сүүлийн 5 жилийн тайлан мэдээллээс дурьдвал:

- Төсвийн тухай хуулийн орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд заасны дагуу мөн оны 1 дүгээр улиралд багтаан нийт өрхүүдэд тус оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар саналын хуудсаа хүргүүлж, багийн ИНХ-ийг хуралдуулдаг

- Иргэдийн оролцоог хангаж байгаа сайн туршлагыг Жаргалант сум нэвтрүүлж “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын санал авах, хянахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийг хэрэгжүүлж, “Сумын ОНХС-гийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд иргэдийн оролцоотой хяналт тавих журам”-ыг батлан, мөрдөж ажиллаж байна.

- Буянт, Дөргөн, Алтай, Дарви, Цэцэг сумд худалдан авах ажиллагаанд иргэдийн бүлгийг оролцуулан оролцоог ханган ажиллаж байна.

- Сумдууд ОНХС-гийн талаар мэдээллээ иргэдэд сурталчилдаггүй нь иргэдийн оролцоог хангах боломжийг олгодоггүй, шаардлагтай мэдээлэл

хангалттай хүрдэггүй нь иргэд идэвхи санаачлага муутай байдагт нөлөөлдөг нийтлэг алдаа сумдад байна

- Мөнххайрхан, Алтай, Дөргөн, Жаргалант зэрэг сумууд мэдээллийн самбар ашиглаж байна. Зарим сумын ИТХ-ын төлөөлөгч, ЗДТГ-ын мэргэжилтнүүд өөрсдөө мэдлэг мэдээлэлгүй байгаа зөрчил байна.

- Иргэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн үр дүнтэй ажлуудад сумын цэцэрлэгт хүрээлэн, халуун ус, гудамж төсөл, гэрэлтүүлгийн ажил, багийн төвүүд, засвар үйлчилгээний ажил, бизнес инкубатор төв, худаг, уст цэг гаргах, мал угаалгын вайн зэргийг нэрлэсэн байна.

- Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээ, зориулалтын бус, хориглосон заалттай зүйлд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулсан тохиолдлууд байна. Тухайлбал төсөвт байгууллагын засвар үйлчилгээ, өмнөх оны болон бусад төрлийн өр төлбөрт шилжүүлэх, тахилга ёслол, төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал зэрэг

- ОНХС-гийн хөрөнгийн хэмжээ буурсан, батлагдсан төсвөөсөө багасч ирдэг, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэхэд санхүүжилт хугацаанаасаа хоцорч ирсэний улмаас хэрэгжихгүй байх, дутуу хэрэгжих зэрэг асуудлууд үүсдэг байна.

## **ДҮГНЭЛТ**

Ховд аймгийн ТА-3 төслийн чадавхи бэхжүүлэх багийн тайлан мэдээлэл, судалгааны дүнгээс харахад ОНХС-гийн ЖГҮ-г сайжруулахад дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна.

- ОНХС-гийн үйл ажиллагааг зохион байгууладаг эрх бүхий албан тушаалтангуудыг чадавхижуулах, дадлагажуулах сургалт, харилцан туршлага судлах, соён гэгээрлийн ажлыг тогтмол давтамжтай, үр дүнтэй зохион байгуулж хэвших. Ялангуяа ОНХС-гийн хүрээнд төсөл боловсруулах, батлах, төсвийн гүйцэтгэлийг хангах, бүртгэх тайлагнах, дотоод болон хөндлөнгийн хяналт, иргэд, олон нийтийн хяналт зэрэг чиглэлүүдээр зохион байгуулах.

- Иргэдийг ОНХС-гийн талаар бодитой мэдээллээр тогтмол хангах, оролцооны бүх хэлбэрүүдэдийг ашиглах, иргэдийн бүлэг, хяналтын бүлгийг дэмжих

- Багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга, Төлөөлөгчдийг өрх бүрт хүргэж ажиллуулахад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг байх.

- АЗ сертификаттай сургалтанд хамрагдаж буй иргэдийн тоог нэмэгдүүлэх, хяналтын бүлэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Орон нутгийн иргэдээс ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой саналуудыг нэгтгэн үзвэл:

- Иргэдийг ОНХС-гийн талаар бодитой, хэрэгцээтэй мэдээллээр хангах
- Иргэдийг оролцооны бүх хэлбэрүүдэд оролцуулах, иргэдийн бүлэг, хяналтын бүлгийг дэмжих
- Санхүүжилтыг оны эхэнд оруулах
- Санал авах ажиллагааны олон хэлбэрийг нэвтрүүлэх, өрх бүрийг хамруулах, идэвхижүүлэх
- ОНХС-гийн чиглэлээр багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, Төлөөлөгчдийг чадавхижуулах, дадлагажуулах
- Багийн ИНХ-д тодорхой хэмжээний санхүүгийн болон техник хэрэгслийн дэмжлэг олгох хэрэгцээ байна.

### **НОМ ЗҮЙ**

- [1] Төрийн албаны тухай хууль УБ., 2018
- [2] Төрийн удирдлага. ШУТИС. ред Б.Долгор, А.Болормаа УБ., 2019 он
- [3] Батсүх Ш. Улсын салбарын шинэ удирдлага (Турилага, сургамж). УБ., 2009 он
- [4] Баярмаа Г. Бүтээмжийн мотиваци. УБ., 2009 он
- [5] Жоди Золл Кусек, Рей С.Рист. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам. УБ., 2010 он
- [6] МУТАЗ. Төрийн захиргааны шинэтгэл: Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт ба нийгмийн аудитын арга зүйг ашиглах нь. УБ., 2006 он
- [7] МУТАЗ. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг удирдахуй: Гүйцэтгэлийн гэрээ, түүнийг үнэлэх үйл явцыг төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг сайжруулахад ашиглах нь. УБ., 2008 он
- [8] Тони Бовэйрд, Элке Лейффлер. Улсын салбарын менежмент, засаглал. УБ., 2014 он
- [9] Энхмандах Ц. Төрийн захиргаа сэтгүүл, 2014 он, №1
- [10] Armstrong, M (2009) *Armstrong's handbook of human resource management practice. 11<sup>th</sup> edition. Kogan page, London*
- [11] Ewan Ferlie; Laurence E. Lynn; Christopher Pollitt (2005) *Handbook of Public Management. The Oxford Press*
- [12] <http://cdc.mn/blog/> Гүйцэтгэлийн удирдлагыг нэвтрүүлэхдээ бид юунд алддаг вэ?
- [13] <http://cdc.mn/blog/> Үнэлгээ бол аргачлал болохоос тогтолцоо биш